

**ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН УДИРДЛАГЫН
ШИЙДВЭР ГАРГАЛТАД ХИЙМЭЛ ОЮУН НӨЛӨӨЛӨХ НЬ****THE INFLUENCE OF ARTIFICIAL INTELLIGENCE ON
DECISION-MAKING IN LAW ENFORCEMENT LEADERSHIP**Автоматизация
внутренних дел**Н.Өсөхжаргал**

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч

N. Usukhjargal

Officer in charge of planning at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Lieutenant

С.Солонго

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын Эрдэм шинжилгээ, инновацын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч

S. Solongo

Senior Officer in charge of Research and Innovation Policy at Research and Innovation Department, University of Internal Affairs, Mongolia, Police first Lieutenant

*хариуцлагатай зохиогч: az.usuhjargal@gmail.com

Хураангуй: Хууль сахиулах байгууллагад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалах үүднээс тодорхой шийдвэрүүдийг гаргах хэрэгцээ, шаардлага алхам тутамдаа тулгарсаар ирсэн.

Эдгээр салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дижитал програмууд нэвтэрч эхэлснээр удирдлагын шийдвэрт тодорхой нөлөөг үзүүлж эхэллээ. Хамгийн гол нь бодит байдлыг үнэлсэн, тодорхой шинжлэх ухаанд суурилсан, богино хугацаанаас илүү урт хугацааны явцад үр дүнтэй байж болох шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх судлаачдийн анхаарлыг татсан хэвээр байна.

Шинэчлэлтэд бид дасан зохицож ирээдүйн үйл ажиллагааг хэрхэн уялдуулж, цаашдын стратеги, хөгжлийн загварчлалыг боловсруулж, тодорхой алхмуудыг хийх шаардлагатай нөхцөл байдал үүссэнийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Иймд бусад улс орны хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлээд буй санал санаачилгаас Монгол Улсын хэмжээнд нийтлэг байдлаар хэрэгжүүлж болох хамгийн тохиромжтой хувилбараар санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: Law enforcement agencies have been faced with the need and requirement to make specific decisions at every step to implement laws, maintain public order, ensure public safety, fight crime, and protect the rights of citizens and legal entities.

As artificial intelligence and digital applications have begun to penetrate the daily operations of these industries, they are beginning to have a significant impact on management decisions. Most importantly, researchers are still concerned about whether they can make decisions that are based on reality, based on clear science, and that can be effective in the long term rather than the short term.

We must recognize that the situation has arisen that requires us to adapt to the changes and coordinate future activities, develop further strategies and development models, and take specific steps.

Therefore, we aim to propose the most suitable alternative that can be implemented universally across Mongolia, based on the initiatives that law enforcement agencies in other countries have implemented.

Түлхүүр үгс: Хууль сахиулагч, шийдвэр гаргалт, судалгаанд суурилсан шийдвэр гаргалт, төрийн тусгай албаны шийдвэр гаргалт, асуудлыг таамаглах дүн шинжилгээний арга зүй, мэдээлэлд суурилсан стратеги.



Хууль сахиулахуй

Keywords: Law enforcement, decision-making, research-based decision-making, decision-making in government agencies, problem analysis methodology, data-driven strategies.

Үндсэн хэсэг

Байгууллагын удирдлагын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсэд ялангуяа 2020 оноос хойших судалгаануудад дижитал шинжилгээний үр дүнг ашиглах чадварын тухай ойлголтууд хүч түрэн орж ирсэн.

Технологийн сэтгүүлээс 2025 онд шийдвэр гаргалтын чиг хандлагад уламжлалт технологиос хүн болон хиймэл оюун ухаан хоорондын хил хязгаар ойртож, илүү боловсронгуй, бие даасан систем рүү шилжих байгааг дурдаж, 2025 онд л байгууллагууд шийдвэрийнхээ 15 хувийг хиймэл оюун ухаанд захирагдаж гаргана гэж онцолжээ. Үүнд дараах таамаглалуудыг дэвшүүлсэн. (Technology magazine, 2025)

1. Хиймэл оюун ухааны шийдвэр гаргалт 15 хувьд хүрнэ. Хиймэл оюун ухаан нь 2025 оны удирдлагын шийдвэр гаргалтын 15 хувийг, 2028 он гэхэд өдөр тутмын ажлын шийдвэр гаргалтын 15 хувийг эзэлнэ.

2. AI засаглалын платформууд. AI засаглалын платформууд нь хиймэл оюун ухааныг хариуцлагатай хэрэгжүүлэх хэрэгцээ өсөн нэмэгдэж, 2028 он гэхэд хиймэл оюун ухаантай холбоотой ёс зүйн зөрчил 40%-р буурна.

3. Хуурамч мэдээллийг илрүүлэх технологи. Дээрх аюул заналхийллийг илрүүлж, бууруулахад хиймэл оюун ухааныг ашиглаж, худал мэдээлэл тархахтай тэмцэж эхэллээ.

4. Квантад тэсвэртэй алгоритмуудыг боловсруулж байна. Google, IBM, Microsoft компаниуд квантад тэсвэртэй алгоритмуудыг боловсруулж байгаа бөгөөд АНУ-ын Үндэсний Стандарт, Технологийн Хүрээлэн (NIST) 2024 оны 8-р сард шинэ PQС стандартаа зарлаж, салбарын шилжилтийг удирдан чиглүүлэв.

5. Хиймэл оюун ухаанд суурилсан дуут туслахууд. Гэмт хэргийн байцаалт, мэдүүлэгт ашиглаад эхэлсэн. Мөн сэтгэцийн эрүүл мэндийг нүүрний хувирлаар тогтоох боломжтой болсон.

6. Эрчим хүчний хэмнэлттэй тооцоолол. Мэдээж мэдээллийг боловсруулах гэдэг бол эрчих хүчийг маш ихээр зарцуулж буй Microsoft дата төвүүдээ 100% сэргээгдэх эрчим хүчээр хангах үүрэг хүлээсэн. АНУ-ын Эрчим хүчний яамны Үндэсний эрчим хүчний судалгааны шинжлэх ухааны тооцооллын төв нь GPU хурдасгасан кластерууд нь зөвхөн CPU-тэй харьцуулахад эрчим хүчний үр ашгийг 5 дахин сайжруулах боломжтойг харуулсан. Ийм мэт эрсдэл арилах тусам салбарын хөгжил илүү нэмэгдэж, орон зайгаа тэлэх зүй тогтолтой байдаг.

7. Гибрид тооцоолол нь инновацын үр ашигтай орчныг бий болгоно. Асуудалд олон арга, програмуудын нэгтгэн шинжилгээ хийх.

8. Орон зайн тооцоолол. Орон зайн тооцоолол нь ойрын 5-7 жилийн хугацаанд “хялбаршуулсан ажлын урсгал болон сайжруулсан хамтын ажиллагаа”-аар байгууллагын үр нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх болно.

9. Олон үйлдэлт роботууд. 2030 он гэхэд хүмүүсийн 80% нь ухаалаг роботтой өдөр бүр холбогдох болно гэдгийг онцоллоо.

10. Хүмүүс өөрсдийн бодлоор төхөөрөмж удирддаг болно. Элон Маск хүний сэтгэхүйгээр дамжуулан төхөөрөмжийг удирдах тархины суулгацыг шинэчлэх төслийг хэрэгжүүлж байна.

Энэ үзүүлэлтийг харахад бодит бус зүйл мэт боловч магадгүй цаг хугацааг эргэн санахад хууль сахиулах салбарын тогтолцоо нь 2000 оныг хүртэл ихэвчлэн захиргааны шинж чанартай буюу осол гарсны дараа бүртгэл эхлэх, хулгай гарсны дараа арга хэмжээ авах, гал гарсны дараа эсхүл үер болсны дараа, хилийн зөрчил гарсны дараа мэдээлэх зэрэг цаасан дээр суурилсан ажлын урсгалыг тойрон эргэлдэж магадгүй илрүүлэх биш баримтжуулахад гол анхаарлаа хандуулж байсан гэхэд хилсдэхгүй.

Гэвч орчин үеийн хууль сахиулах орчин эрс өөрчлөгдсөн.



Гэмт хэрэг дангаараа гарахаа больж, харилцаа холбооны сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төхөөрөмж, хяналтын системд дижитал ул мөр үлдээдэг. Энэхүү ул мөр нь өөрөө нотлох баримт, сэрэмжлүүлэг болж, хохирогчдод хохирохгүй байх сонголт байсныг, аюул эрсдэлийг тооцох боломж байсныг, мэдээллийн үнэн зөвийг нягтлах боломж байсныг сануулах бараг л хиймэл ухаан, дижитал программд суурилсан урьдчилан сэргийлэлт ч болж байна.

Мөн хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамж нь өнөөдрийг хүрсэн хууль сахиулах салбарын хөгжлийн хамгийн хурдацтай үсрэлтийг харуулж мөрдөн байцаалт, тандалт, шүүх шинжилгээ, зөрчлийг илрүүлэх, гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээ зэрэг танин мэдэхүйн системийн хэрэглээнд тодорхой байр, суурийг эзэлжээ.

Тухайлбал: Хууль сахиулах салбарын удирдлагын шийдвэрт

1. Өгөгдлийг шинжилж, орхигдуулсан сэжүүрийг таамаглах процесс;
2. Цахим сүлжээнд дуудлагын бичлэг, мессеж, камерын бичлэгээс нүүрний хэлбэрт үндэслэн хайлт хийх;
3. Шүүх эмнэлгийн өгөгдөл нэгтгэх зэрэг шинэ технологиуд нөлөөлж эхэллээ.

Үүний үр дүнд шинээр гарч ирж буй аюул заналыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр урьдчилан харж, илрүүлж, хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж, зөвхөн урьдчилан таамаглаад зогсохгүй шийдвэр гаргах бүх шатанд үйл ажиллагаа хэрхэн явахыг төсөөлөх боломжтой болсон.

Магадгүй цаашид хууль сахиулах салбараар ч тогтохгүй бүхий л байгууллагын шийдвэр автоматчилагдаж, ганцхан товчлуураар асуудлын учрыг олдог болох хөгжил рүү хурдацтайгаар шилжиж байж ч болох.

Гэхдээ судлаачдын зүгээс шийдвэр гаргалтад нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл болох хүний ёс зүйн төлөвшил орхигдоод байгааг анзаарахгүй өнгөрөөж болохгүй бөгөөд удирдлагууд дижитал

программ болон технологийн дэвшлүүдийг ашиглахдаа болгоомжтой байхыг ахин дахин сануулсаар байна.

Байгууллагын Удирдлага болон удирдах зөвлөлийг томоохон дата станц дээрээс үйл ажиллагааг хараад сууж байгаа аварга AI боловсруулагч гэж ойлгож болох юм. Асар их мэдээлэлд автсан эдгээр хүмүүс шийдвэр гаргахын тулд энэхүү мэдээллийг үр дүнтэй ашиглах л тулгамдсан асуудал нь болоод байгаа. Гэвч хэн ч ирээдүйг нарийн тооцож чадахгүй. Харин ирээдүйг таамаглаж, бодит байдалд илүү ойрхноор төсөөлж болох бүх боломж тэдэнд байна. Байгууллага доторх шийдвэр гаргах үйл явцыг оновчтой болгосноор мэдээллийн нарийн төвөгтэй байдал, хэмжээ нь шийдвэр гаргагчдын чадварыг хойш нь татах бус бусад саадыг даван туулах, тодорхой арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бий болгох юм.

Үүнийг олон улсад Management information буюу удирдлагын мэдээлэл гэх ойлголтоор судалгаанд түлхүү ашиглаж, мэдээллийг стратеги, үйл ажиллагаа, тактикийн шийдвэрүүдийг удирдах ач холбогдолтой тагнуул (Erica, Gantari, Olivia , Asher , & Omar , 2024) гэж хүртэл тодорхойлсон.

Сүүлийн жилүүдэд байгууллагын Дата шинжээч гэсэн мэргэжил хүртэл ажлын байранд хүч түрэн орж ирэхээс гадна, янз бүрийн программ хангамжууд хурдацтайгаар хөгжиж байна. Магадгүй таны ажлыг хөнгөвчлөх нарийн үйл ажиллагаатай зөвлөх үйлчилгээ ч байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ шийдвэр гаргалт бүрд эдгээрийг ашиглаад байх нь оновчтой бус бөгөөд хөрөнгө, цаг хугацааны хувьд ч харилцан үр ашиггүй байна.

Үүнийг дэлхий дахинд хэрхэн шийдвэрлэхээр зорьсон бэ? Хэд хэдэн боломжит хувилбаруудыг санал болгосоор байна.


1. Удирдагч бэлтгэх сургалт: Сургалтын хөтөлбөрт энэхүү хөтөлбөрийг тусгаж эхэлсэн. Тухайлбал Харвардын их сургуулийн Бизнесийн сургуулийн Манлайлал хөгжүүлэх хөтөлбөрийн дижитал хувиргалтын хөтөлбөр. Тус хөтөлбөрийн зорилго нь “Хөгжиж буй



МОНГОЛЫН ХУУЛЬ САХИУЛАХЫН УДИРДЛАГА

технологийг ашиглаж таны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийж, статистикийн муруйг түрүүлж хараарай” (Harvard, 2025), Манчестарын Их сургуулийн Бизнесийн сургуулийн Манлайллын 4 өдрийн сургалтын зорилго нь “Байгууллагын гүйцэтгэл, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бизнесийн шинэлэг стратегийг хэрэгжүүлэхэд технологийг ашигла” (The University of Manchester).

2. Байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн системд холбож, алба хаагчдын өгөгдлийг удирдах албан тушаалтан ганц дэлгэцээр харах боломжтой хувилбар. Тухайлбал: Олон улсын цагдаагийн дарга нарын холбоо (IACP-International




3. Ажлын байрны шаардлагад тавих: Өөрөөр хэлбэл удирдах албан тушаалтаас энэхүү ур чадвар заавал буйг шаардах бөгөөд байгууллагын онцлогоос хамаарч тоон болон чанарын судалгааны ур чадваруудыг эсхүл бүр холимог байдлаар ашиглах боломжтойг давуу тал болгож байна.

Энэ төрлийн ур чадвар нь статистикийн онол, эдийн засгийн мэдрэмжид ихээхэн суурилж буй тул ирээдүйд математикч, эдийн засагчид илүү удирдах албан тушаалыг эрхлэх байх гэсэн таамаглалыг дэвшүүлсэн судалгаа байна (Kumar, 2024). Үүнээс харахад бусад мэргэжлийн болон бусад салбарын удирдах албан тушаалтнууд энэхүү чадварт суралцах нь зайлшгүй болсон мэт.

Иймд удирдлага бүхэнд хамгийн ихээр тулгарч болох тулгарснаас үүсээд шийдвэрээ өөр хүчин зүйлсийн нөлөөнд

association of chiefs of police)-ноос “Хиймэл оюун ухааны эрин ба орчин үеийн цагдаагийн программ хангамж: өгөгдөл боловсруулалт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлэх эсэх” (Policing Software in the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention, 2025) тайланг танилцуулсан.

Тайланд олон сайн чанар, хэрэгжүүлэх боломж, цаг хугацаа болон эдийн засгийн үр нөлөөг тайлбарласан ч хүний ёс зүйд нийцэх өгөгдөл одоогоор программчлах боломжгүй тухай дурдсан. Энэ арга бол хамгийн энгийн боловч үүнийг дагаад сул талууд байх магадлалтайг зарим судлаачид хүлээн зөвшөөрсөн байна.



автан гаргах нөхцөлийг үүсгэх эхний асуудал бол та асуудалд чанарын аргыг үндэслэн хандах уу? Эсхүл тоон шинжилгээнд үндэслэн хандах уу? гэх сонголттой нүүр тулах, дагаад программын сонголтыг ч хариулахад нөлөөлнө.

Судлаачдын зүгээс удирдах албан тушаалтан шийдвэр гаргахдаа өөрт буй мэдээллээсээ хамааран дээрх 2 аргаас аль тохиромжтойг сонгох боломжтойгоор төрийн тусгай албаны үйл ажиллагааны жишээн дээр эрэмбэлэн санал болгож байна.

Төрийн тусгай албаны өдөр тутмын үйл ажиллагаа нь нийтлэг байдлаар удирдлагын процесс, үндсэн үйл ажиллагааны процесс, дэмжих үйл ажиллагааны процесс гэсэн 3 хэсэгт тодорхой асуудлыг шийдвэрлэн, шийдвэрийг хэрэгжүүлэн зохион байгуулагддаг.



1. Удирдлагын процесс бол зохион байгуулалт, үнэлгээ, цалин, урамшуулал гэх мэт алба хаагчдад чиглэсэн үйл ажиллагаанууд байх бөгөөд илүү чанарын шинжилгээ тохиромжтой.

Жишээлбэл: Алба хаагчийн ажлын ачааллыг тодорхойлох судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа, урамшууллын систем болон төлөвлөлт зохион байгуулахад программд суурилсан судалгаа үр дүнгүй бөгөөд судалгааны асуулгад алба хаагч цөөн үгээр илэрхийлэх боломжгүй нөхцөл байдлууд орхигдоод байх тал ажиглагддаг бөгөөд буруу хувьсагчийн гажуудлаас үүсэн судалгааны үр дүн бодит байдалд нийцэхгүй байдал үүсгэдэг.

Иймд энэ төрлийн судалгааг фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, нээлттэй санал асуулга гэх мэт илүү харилцаанд тулгуурласан шинжилгээ тохиромжтой ба MAXQDA, NVIVO программууд илүү тохиромжтой.

2. Үндсэн үйл ажиллагаа бол иргэдийг аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн байх тул үйл ажиллагаа улс орны хэмжээнд ерөнхийлөн шийдвэр гаргалдаг тул тоон шинжилгээний аргууд тохиромжтой.

Жишээлбэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, хил орчмын харуул хамгаалалт, гал түймрээс урьдчилан сэргийлэх гэх зэрэг хугацаан цувааны өгөгдөл их, жилийн болон сар, улирлын байдлаас харгалзан өсөх буурах үзүүлэлтүүд гаргаж байдаг, үзүүлэлтийн ажиглалтаас үүсэх давтамжийг тодорхойлох, шийдвэрт ерөнхийлөн ашиглах боломжтой.

Хэрэгжилт үр дүнд хүрэх магадлал аль ч салбарт өндөр хувийг хамрах тул нэг

байгууллагын загварыг нөгөө байгууллага шилжүүлэн ашиглах ч боломжтойгоороо онцлог ба SPSS, R хэрэглээний хувьд хамгийн нөхөрсөг сонголт байна.

3. Дэмжих үйл ажиллагаа бол алба хаагчдын ажлын ачаалал, нийгмийн баталгаа, эрүүл мэнд гэх мэт хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн үйл ажиллагаа тул тоон болон чанарын шинжилгээ аль аль нь тохиромжтой байна.

Жишээлбэл: Үйл ажиллагааны шинж чанарын хувьд ажил олгогч ба ажилтан хоёрын эрх ашгийг нэгэн зэрэг хамгаалдаг процессууд хамаарах тул тоон болон чанарын судалгааг хослуулан хэрэглэснээр илүү нарийн шийдвэрүүдийг гаргахад тань тусална.

Удирдлагын аливаа шийдвэрийн гол зорилго бол тодорхой асуудлыг шийдвэрлэх. Асуудлын цаана алба хаагчид, үүнээс гадна гадаад, дотоод харилцагчид бий. Эдгээрийн хүсэл зоригийг 100 хувийн тааламжтайгаар хангах боломжгүй. Мэдээж дундаж буюу 60 хувиас их бүрэлдэхүүний асуудлыг шийдэж чадвал шийдвэр хамгийн оновчтой болох магадлалтай. Үлдсэн хэсэг асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг нээлттэйгээр мэдэж буй тул хүсээгүй үр дүн ч хамгийн шударга хэмжүүр гэхтэй санал нийлдэг.

Иймд магадгүй бид аливаа асуудалд практик туршлага, дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэлээ гэхээс бодит шинжлэх ухааны нотолгоо илүү итгэл төрүүлдэг ч байж магадгүй байх нь.

Хууль сахиулах байгууллагын удирдлагын шийдвэрт хиймэл оюун ухаан, дижитал программ хангамжийг ашиглаж буй өнөөгийн байдалд “SWOT”, “TOWS” шинжилгээ хийж үзье.

	Давуу тал-S	Сул тал-W
Дотоод хүчин зүйл	- Мэдээллийн шуурхай боловсруулна. - Эрсдэлт хүчин зүйл бага. - Бусад улсын туршлагаас судлах боломж их. - Бүх шатны сургалтын хөтөлбөрт энэхүү сургалтын загварыг нэвтрүүлэх боломжтой.	- Эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул. - Байгууллагын санхүүгийн чадамж сул тул худалдан авалт шуурхай бус. - Сургагч багшийн нөөцгүй. - Алба хаагч, сургалтын байгууллагын уялдаа сул.
Гадаад хүчин зүйл		



Хууль сахиулах үйлчилгээний төв

	- Суралцах орчин хангалттай.	- Ажлын ачаалал их тул алба хаагчид шинэ зүйлийг турших мотивац сул.
Боломж-О	OS стратеги	OW стратеги
- Үйл ажиллагааны журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. - Гадаадын байгууллагуудтай хамтарч сургалт, бэлтгэлийг зохион байгуулах боломжтой. - Ахисан түвшний хөтөлбөрт хамрагдах боломжтой.	- Эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, - Урт болон богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, - Хууль сахиулагчийг бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгаж, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	- Ажлын байранд хөгжих уялдаа холбоог хангасан тогтолцооны загварт оруулах. - Хууль сахиулагчийн ажлын байрны сургалтын ангиллыг шинэчлэх. - Сургалтын үр дүнгээр ахиж, дэвших боломжийг тогтоох.
Эрсдэл /Аюул занал/-Т	ST стратеги	WT стратеги
- Ашиглах арга технологийг бүрэн эзэмших хүртэл үйл ажиллагааны хурд удаашрах эрсдэлтэй. - Ажлын байранд хүний нөөцийн хомсдол бий болох эрсдэл үүсэх.	- Сургалтын орчин, анги танхим хүрэлцээтэй тул давтан сургах, нэмэлт төхөөрөмжүүдийг холбох дэд бүтцийн нөөц сайтай.	- Санхүүгийн нөөц нь давтан сургах, гэрээ, лицензийг сунгах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх.

Хүснэгт 1. “SWOT”, “TOWS” шинжилгээ

“SWOT”, “TOWS” шинжилгээнээс үзэхэд, Монгол Улсын хувьд эрх зүйн орчин сул, санхүүгийн болон хүний нөөцийн хомсдол их байгаа нь урт хугацааны хөтөлбөрүүдэд одоогоос анхаар ажиллах шаардлагатайг илтгэж байна.

Гэвч боломжийг ашиглаж асуудалд бодит дүгнэлт хийж, бүх шатны байгууллага аажмаар нэвтрүүлэхэд анхаарч сул талаа арилгах, давуу талаараа аюулаас зайлсхийх боломжтой гэж үзэж байна.

Санал, дүгнэлт

Нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл өөрчлөгдөх үйл явцын үр дүнд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход иргэдийн оролцоо, олон нийтийн боловсролыг дэмжих чиг хандлагыг баримталхаас гадна бодит өгөгдөлд суурилж асуудлыг шийдвэрлэхэд

анхаарч байгаа ч ялагуяа аль ч төрлийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа хийсэл оюуны ухаан болон дижитал программыг ашиглах хэрэгцээ үүссэнийг ухаарч Хууль сахиулах байгууллага удирдах албан хаагчдаас эхлээд бүхий л түвшний алба хаагчдыг сургаж, бэлтгэх, технологийн нөөцийг бүрдүүлэх хэрэгцээ ихээхэн байна.

Монгол Улсын хууль сахиулах байгууллагын хувьд санхүүжилтийн байдал нь эрсдэлт хүчин зүйл байх тул өнөөгийн үйл ажиллагаанаас эхлэн аажмаар шилжих стратеги хэрэгжүүлж эхэлж байх нь хамгийн тохиромжтой сонголт тул хүний нөөцийг бэлтгэх асуудалд анхаарч байхад ирээдүйд ирэх зарим үр дагавраас зайлсхийх боломжтой байна.

Удирдлагууд шийдвэр гаргалтдаа хиймэл оюун ухаан, дижитал программ хангамжийг ашиглаж хэвшсэнээр дан ганц шийдвэрийн алдааг багасгах бус байгууллагын үйл ажиллагааг энэ чиглэлд бэлтгэх бас нэг суурь хүчин зүйл болж байгааг анхаарч байгууллагын соёлыг тогтоож эхлэх шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

Erica, A., Gantari, L., Olivia, Q., Asher, N., & Omar, S. (2024). Optimizing Decision-Making: Data Analytics Applications. APTISI Transactions on Management (ATM), E-ISSN: 2622-6804 P-ISSN: 2622-6812, <https://pdfs.semanticscholar.org/e491/a5802756f1ebca816fd0e460ca5c3c8c5f1c.pdf>. doi:DOI:10.33050

Harvard . (2025). Harvard Business School. Retrieved from <https://www.exed.hbs.edu/programs/learning-tracks>, <https://www.exed.hbs.edu/programs/learning-tracks/digital-transformation-certificate>.

IACP (International Association of Chiefs of Police). (2025). Policing Software in

the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention. USA: IACP. Retrieved from Policing Software in the Age of AI: From Reactive Reports to Proactive Crime Prevention.

Kumar, R. (2024). California School of Management and Leadership. Retrieved from <https://www.alliant.edu/blog/what-are-most-common-management-careers>.

Technology magazine. (2025). Retrieved from <https://technologymagazine.com/articles/top-10-trends-of-2025>.

The University of Manchester . (n.d.). Alliance Manchester Business School. Retrieved from https://www.alliancembs.manchester.ac.uk/go/short-courses-greater-manchester/?gad_source=1&gad_campaignid=22291749757&gbraid=0AAAAADCTIFoSjIyfbFWdfiNsK6mm4ahV&gclid=CjwKCAiAlrXJBhBAEiwA-5pgwlLa-F5CLyRG9_NSOG9pvBD4l-Xf_wXU01XPR7I5T_TMKkyUymYR2BoCj1kQAvD_B.



International Association of Chiefs of Police